

БАТЛАВ: СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
БОАЖГ-ЫН ДАРГА

З.ТҮВШИНТӨГС



“БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
АЖИЛТНУУД, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ, БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧДЫН АЖЛЫН  
ХУВЦСЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ” АЖЛЫН ДААЛГАВАР

2024.02.05


№	Ажил гүйцэтгэх үндэслэл	БОАЖСайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/451 дүгээр тушаалаар баталсан “Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, БОАЖ-ын салбарын ажилтнуудын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд БОАЖГ-ын ажилтнууд болон байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдыг халуун, хүйтэн цаг улирал, хээр, хөдөөгийн нөхцөлд өмсөх ажлын хувцсаар жигд хүртээмжтэй хангах
1	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал
2	Санхүүжилт	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 142 тоот тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал” 46.530.000 төгрөг
3	Захиалагч байгууллага	Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
4	Байршил	Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум
5	Ажлыг гүйцэтгэх хугацаа	2024 оны 02 дугаар сарын 15-наас 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдөр
6	Гүйцэтгэх ажлууд	БОАЖГ-ын ажилтан 16, байгаль хамгаалагч 28, улсын байцаагч 20, нийт 64 хүнд 4 улирлын буюу эрэгтэй, эмэгтэй хослол, өвөл зуны малгай, цамц, зангиа өвөл, хавар, намрын ажлын хувцас хийх, үүнд: - Хөх өнгийн хагас ноосон даавуугаар материалаар хийгдсэн дүрэмт хувцасны загвартай пиджак, шулуун загварын өмд, өвдөг үл ялиг өнгөрсөн урттай банзалтай эрэгтэй, эмэгтэй костюм, - Хар хөх өнгийн торгомсог материалаар хийгдсэн зангиа, - Хөх саарал өнгийн даавуун материалаар хийгдсэн хавар, намрын хүрэм, - Хөх саарал өнгийн даавуун гадартай, хүрэм өмдний хослол, хиймэл үсэн дотортой, хөх өнгийн, салдаг хиймэл үсэн болон нэхий захтай, өвлийн хувцас: - Хар өнгийн даавуун материалаар хийгдсэн ажлын хээрийн хувцас, - Хөх өнгийн даавуун материалаар хийгдсэн жижиг саравчтай зуны нарны малгай,

		- Үсийг нь тайрч, хөх өнгөөр будсан нэхий буюу хиймэл үстэй, сөхөж буулгадаг өвлийн малгай: - Цагаан болон цэнхэр өнгийн даавуун материалаар хийгдсэн, хээ судалгүй сорочкон цамц зэрэг.
7	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	Ажил гүйцэтгэгч нь хуулийн этгээд байна, оёдол эсгүүрийн чиглэлээр 3 жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай, ажлын болон албаны хувцас хийж байсан туршлагатай байх шаардлагатай
8	Онцгой нөхцөл	Байхгүй

Ажлын даалгавар боловсруулсан:

Байгаль орчны хяналтын албаны дарга,  
улсын ахлах байцаагч

Нягтлан бодогч







Н.Эрдэнэцогт

Б.Минжээ


### БОАЖГ-ЫН АЖИЛТНУУДЫН ХУВЦАСНЫ ЗАГВАР

1. Байгаль орчны хяналтын ажилтнуудын хувцас нь эрэгтэй, эмэгтэй костюм, өвөл зуны малгай болон цамц, зангиа өвөл, хавар, намрын ажлын гэж ангилагдана.
2. **Эрэгтэй, эмэгтэй костюм:** Хөх өнгийн хагас ноосон даавуугаар хийгдсэн дүрэмт хувцасны загвартай пиджак, шулуун загварын өмд, өвдөг үл ялиг өнгөрсөн урттай банзалтай байна. Зүүн ханцуй дээр байгаль орчны газрын ялгах тэмдгийг хадсан байна. Зүүн энгэр дээр төмрөөр товойлгон хийгдсэн БОАЖГ-ын эмблемийг зүүнэ.
3. **Зангиа:** Хар хөх өнгийн торгон материал дээр “БОАЖГ” гэсэн товчилсон үгийг тод шар өнгөөр бичсэн. /Энэ бичиг нь хувь хүний сонголтоор/. Эрэгтэй нь ердийн зангиддаг, эмэгтэй нь нарийн цахилгаан тохируулагчтай байна.
4. **Хавар, намрын хүрэм:** Хөх саарал өнгийн даавуун материалаар хийгдсэн, энгэртээ ил тагтай 4 ш хөндийрүүлэгчтэй карматай, тагандаа кнопон товчтой, энгэртээ цахилгаантай, цахилгаанаа дарсан хаалттай, хаалтандаа кнопон товчтой, зүүн ханцуй дээр байгаль орчны газрын ялгах тэмдгийг хадсан зүүн дээд энгэрт “Байгаль орчин, аялал жуулчлалын газар” гэсэн үгийг Монголоор тод шар өнгийн утсаар хатгаж оёсон наалттай, мөрөндөө мөрдэс тогтоогч хэлтэй, кнопон товч хадсан, зах юүдэн 2-ийг цахилгаанаар холбосон, юүдэнгийн үзүүрт 2 кноптой, ширж хийсэн жижиг саравчтай, орой дээрээ кнопон сойлттой, ар суганы ухаар нь битүү хөндийрүүлэгчтэй, хөндийрүүлэгчийг дотор талд нь өргөн резинээр холбосон, бүсэлхийгээрээ далд бүстэй, шар өнгийн металл товчтой байна.
5. **Өвлийн хувцас:** Хөх саарал өнгийн даавуун гадартай, хүрэм өмдний хослол, хиймэл үсэн дотортой, салдаг хөх хиймэл үсэн болон нэхий захтай, давхарлаж оёсон тохойвчтой хүрэм, өвдөг болог өгзөг хэсэгт давхарлаж оёсон өмд зүүн ханцуй дээр байгаль орчны газрын ялгах тэмдгийг хадсан зүүн дээд энгэрт “Байгаль орчин, аялал жуулчлалын газар” гэсэн үгийг Монголоор тод шар өнгийн утсаар хатгаж оёсон наалттай, мөрөндөө мөрдэс тогтоогч хэлтэй байна.
6. **Ажлын хээрийн хувцас:** Хар өнгийн даавуун материалаар хийгдсэн, урт ханцуйтай, салдаг юүдэн малгайтай, хагас босоо захтай, ар нуруун талдаа хуниасан оруулгатай, өвдөг үл ялиг өнгөрсөн урттай байна. Улсын байцаагч нар ар нуруун дээр “Environmental inspection” гэсэн үгийг тод шар өнгийн утсаар хатгаж оёсон энгэртээ цахилгаантай, цахилгаанаа дарсан хаалттай, хаалтандаа кнопон товчтой, зүүн ханцуй дээр байгаль орчны газрын ялгах тэмдгийг хадсан байна.
7. **Зуны нарны малгай:** Хөх өнгийн жижиг саравчтай, оройн хэсэг бөмбөгөр урд талдаа төрийн соёмбыг шар утсаар хатгаж оёсон байна.
8. **Өвлийн малгай:** Орчин үеийн технологээр боловсруулж үсийг нь тайрч, хөх өнгөөр будсан нэхий буюу хиймэл үстэй, сөхөж буулгадаг, үсийг нь гадагш харуулан хийсэн байна.
9. **Сорочкон цамц:** Цагаан болон цэнхэр өнгөтэй, хээ судалгүй мөрдэс тогтоогчтой, урт, богино ханцуйтай, зүүн баруун энгэртээ тагтай халаастай, эмэгтэй цамц нь зөрүү энгэртэй байна. Зүүн ханцуйнд БОАЖГ-ын таних тэмдэг бүхий тэмдэг хатгаж оёсон байна.


Эрэгтэй, эмэгтэй костюмны загвар /Улсын байцаагч/




Сорочкон цамцны загвар



Хавар, намрын хүрэмний загвар




Өвлийн хувцасны загвар



Малгайн загвар



Зуны нарны малгай



Байцаагчдын өвлийн малгай

## **БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Хөтөлбөрийн зорилго**

1.1. Байгаль хамгаалагчдын хэрэгцээг бодитоор тодорхойлж, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн баталгааг нь хангах зорилготой.

### **Хоёр. Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим, хугацаа**

- 2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:
- 2.1.1. Байгаль хамгаалагч нэг бүрийг хамруулах;
- 2.1.2. Ил тод, нээлттэй хэрэгжүүлэх;
- 2.1.3. Бодитой, үр дүнтэй байх;
- 2.1.4. Нөөц бололцоог бүрэн дайчлах;
- 2.1.5. Бүтээлчээр хандах.
- 2.2. Хөтөлбөрийг 5 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилт**

- 3.1. Хөтөлбөрийг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.
- 3.1.1. Төрийн албан хаагчид хуулиар олгогдсон эрхийг бүрэн эдлүүлж, нийгмийн баталгааг хангах;
- 3.1.2. Байгаль хамгаалагчдын хувь хүний болоод гэр бүлийн хөгжлийг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах замаар тогтвортой, бүтээмжтэй ажиллуулах;
- 3.1.3. Ажил үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.

### **Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ**

- 4.1. Төрийн албан хаагчид хуулиар олгогдсон эрхийг бүрэн эдлүүлж, нийгмийн баталгааг хангах хүрээнд:
  - 4.1.1. Байгаль хамгаалагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах, хууль зөрчигчдийн зүгээс ирж болзошгүй аливаа хавчлага, дарамтыг бууруулах, энэ чиглэлээрх сайн туршлагыг нэвтрүүлэх;
  - 4.1.2. Төрийн захиргааны албан хаагч алслагдсан бүс, орон нутагт байгаль хамгаалагчаар ажиллахад орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар олгох;
  - 4.1.3. Байгаль хамгаалагчид ажлын гүйцэтгэл, үр дүн, хөдөлмөрийн бүтээмжгэй уялдсан урамшуулал олгох, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг жил тутам тооцон олгох нөхцөлийг Төсвийн шинэчлэлийн бодлоготой уялдуулан бүрдүүлэх;
  - 4.1.4. Байгаль хамгаалагчдыг төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд ажил сайжруулах, сайн туршлага нутагшуулах зорилгоор шилжүүлэн болон сэлгэн ажиллуулах;
  - 4.1.5. Үйл ажиллагааны үр дүнг харгалзан гадаад улсын байгаль